

НАГ, Х-1, Д-1, ХН-116

**ХАРЬЯАТ ОЛОН ГАЗРААС ӨРХ АМ, ХӨРӨНГӨ МАЛЫН ҮНЭ ТООГ МЭДҮҮЛЭХҮЙД  
НУУН ДАРАГСДЫГ ЦЭЭРЛҮҮЛЭН ШИЙТГЭХ ДҮРЭМ ХЭМЖЭЭ**

Харьяат олон газраас аймаг шавийн захиргааны ба нутгийн захиргааны дүрмийн ёсоор буюу ардын засгийн газраас тусгайлан тушааснаар өрх ам, хөрөнгө малын үнэ тоог тодорхойлон мэдүүлэхүйд нуун дарсан ба байцаахыг алдагсдыг ялган салгаж, цээрлүүлэн шийтгэх дүрэм хэмжээ.

**НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ.** Аливаа хүн хөрөнгийн малыг нуун дарахуй нь буй аваас нуун дарсан малыг олон цөөнийг үл бодон бүрнээ албанд хураамуй. Үүнд мөнхүү жилийн төл болбоос нуун дарсанд үл тооцмуй.

**ХОЁРДУГААР ЗҮЙЛ.** Хүн амыг нуун дарахуй нь буй аваас нуун дарсан ам нэгээс гуравт хүртэл өрхийн тэргүүлэгчийг мөнгө 27 лан торгож, ам гурав тутам нэгэн зэрэг болгон, зэрэг тутам мөнгө 27 лан нэмэгдүүлэн торгож шийтгэмүй.

**ГУРАВДУГААР ЗҮЙЛ.** Өрх ам, хөрөнгө малыг бүрнээ нуун дарахуй нь буй аваас хүн амын олон цөөнийг үл бодон өрхийн тэргүүлэгчийг мөнгө 81 лан торгож шийтгээд басхүү бүх хөрөнгө малын нэгэн дундуурыг албанд оруулмуй.

**ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ.** Аливаа хүн ам ба хөрөнгө мал нуун дарсан хэрэгт байцаахыг алдсан харьяат арван гэрийн даргыг мөнгө 27 лан, багийн эрх баригчдыг тус бүр мөнгө 21 лан, сум нутгийн эрх баригчдыг арван таваад лан, хошуу шавийн эрх баригчдыг мөнгө есөөд лангаар торгож шийтгэмүй.

**ТАВДУГААР ЗҮЙЛ.** Аливаа хүн, өрх ам хөрөнгө малын үнэ тоог гарган мэдүүлсэн атал харьяат эрх баригчид завсраас хорогдуулан нуун дарсан нь буй аваас өрхийн тэргүүлэгчдийг яллахыг хэлтрүүлж, гагцхүү харьяат эрх баригчдыг уул олбоос зохих ялын дээр тус тус гурваад зэрэг нэмэгдүүлэн торгож шийтгээд өөр өөрийн оролдсон албан тушаалаас огцруулмуй. Үүнд хэрвээ учрыг үл мэдсэн буй аваас хэвээр байцаахыг алдсан ял торгомуй.

**ЗУРГААДУГААР ЗҮЙЛ.** Аливаа торгосон мөнгийг гурван сарын хугацаа хугацаж, хөөн тушаалгамуй. Хааяа уг хугацаанд гүйцэтгэн эс тушааваас шүүх явдлын яамнаа дайчлан ирүүлж дуусган тушаагаагүй мөнгөний лан тутамд хошоод өдөр үйлдвэр хийлгэж шийтгэмүй.

**ДОЛООДУГААР ЗҮЙЛ.** Хүн ам ба өрх хөрөнгө малыг нуун дарсан нь хөндлөн хүн гэрчлэн гаргах аваас уул торгосон мөнгө буюу албанд оруулах малаас нэгэн дундуурыг нь гэрчилсэн хүнд шагнаан олгомуй.

**НАЙМДУГААР ЗҮЙЛ.** Аливаа хүн мал ба өрх хөрөнгө малыг нуун дарсан хэргийг гэрчлэн гаргах хүн ойрыг үзэн харьяат аймаг шавьд суугаа ардын засгийн газрын хөлсний түшмэл

буюу эсэхүл аймгийн яам, Эрдэнэшанзадбын яамнаа мэдүүлэн уламжлан ардын засгийн дотоод явдлын яамнаа өргөн мэдүүлж, магадлан байцааж, гүйцэтгэн шийтгэхүйд бэлтгүүлбээс зохимуй.

**ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ.** Энэхүү дүрэм хэмжээг зарласан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болгомуй.